1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,813,443.00	132,897,323.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,615,300.00	90,091,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,141,943.00	42,311,423.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,056,200.00	494,400.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баяннуур сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Ёндон танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-аас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төвлөлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, гэрээт аудитор У.Мөнхчимэг хариуцаж гүйцэтгэв.

Баяннуур сумын ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 01/72 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баяннуур сумын ерөнхийлөн захирагчийн 2020 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Оновчтой бодлого зохицуулалтаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлж, иргэдээ орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд оршино. ” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих
- Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх
- Төсөв санхүүг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах, хяналт тавих
- Батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах
- Хууль, эрх зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

- Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, мэдээ, мэдээллээр хангах
- Аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам”, сумын Засаг даргын “Шинэ хөгжилд хамтдаа” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баяннуур сумын төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналт 2020 онд хяналт шалгалт хийгээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,506.2 сая төгрөгийн 2 хувь буюу 50,1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 65.7 сая, эцсийн үлдэгдэл 107.4 сая төгрөг болж, 41.7 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	65.7	107.4	41.7	
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	65.7	107.4	41.7	

Эх сурвалж Баяннуур сумын засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 107.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 219.7 сая, эцсийн үлдэгдэл 254.1 сая төгрөг болж 34.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.2... Авлагын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.9		(0.9)
Бусад авлага	218.8	254.1	35.3
Дүн	219.7	254.1	34.4
Үүнээс байгууллагын төрлөөр			
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	13.4	24.8	11.4
Засаг даргын тамгын газар	0.2	4.3	4.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.06	1.7	1.6
Соёлын төв	0.3	0.6	0.3
Сум хөгжүүлэх сан	169.4	181.2	11.9
Сургууль	0.9	0.0	(0.9)
Хүн эмнэлэг	0.0	0.0	0.0
Цэцэрлэг	0.0	6.0	6.0
Эмийн эргэлтийн сан	0.2	0.0	(0.2)
Орон нутгийн ерөнхий орлого	4.8	4.8	0.1
Орон нутгийн хөгжлийн сан	30.4	30.4	0.0
Дүн	219.7	254.1	34.4

Эх сурвалж: Баяннуур сумын засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 241.1 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангаас 2016 онд “Бүрэн сээр” ХХК замын цагдаагийн постыг камержуулах, зарим тоног төхөөрөмжөөр хангах, гэрэлтүүлэх хашаажуулахаар тендерт шалгарсан ч ажлаа гэрээний дагуу гүйцэтгээгүй. Булган аймгийн сум дундын шүүхэд шилжүүлсэн боловч одоог хүртэл шийдэгдээгүй 30.4 сая төгрөгийн авлага байна.
- 2015 онд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2000 оны өвсний үлдэгдэл зөрүүг сумын орон нутгийн ерөнхий орлогоос авах 4.8 сая төгрөгийн авлага байна.
- 2017 оны Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас иргэдийн өвс тэжээлийн 24.8 сая төгрөгийн авлага байна.

Богино хугацаатай зээлийн авлага нь тусгай зориулалтын сан буюу Сум хөгжүүлэх сан, багийн бичил зээлийн сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийг хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг Булган аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж зээлийг барагдуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан ба 66.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж 39.4 хувиар авлага буурсан байна. Мөн зээл авсан иргэдээс 12 иргэн зээл бүрэн төлж барагдуулсан байна. 2020 онд 14 иргэнд 74.5 сая төгрөгийн зээл олгосон байна.

2020 оны байдлаар Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоход:

- 2013 онд зээл авсан 5 иргэдээс 38.1 сая төгрөгийн авлага
- 2014 онд зээл авсан 3 иргэнээс 10.7 сая төгрөгийн авлага
- 2015 онд зээл авсан 1 иргэний 8.2 сая төгрөгийн авлага

- 2016 онд зээл авсан 2 иргэний 1.3 сая төгрөгийн авлага
- 2018 онд зээл авсан 2 иргэний 4.7 сая төгрөгийн авлага
- 2019 онд зээл авсан 12 иргэний 45.5 сая төгрөгийн авлага
- 2020 онд зээл авсан 14 иргэний 75.2 сая нийт 39 иргэний 179.7 сая төгрөгийн авлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг зөрчин 6.0 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Тайлант онд орон нутаг болон тусгай шилжүүлгийн байгууллагууд авлага бууруулах арга хэмжээг авч ажилласан хэдий ч ЗДТГ, ИТХ нягтлан бодогч НДШ, ХАОАТ тооцоолол буруу хийж 6.1 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн байна. Мөн тайлант онд сум хөгжүүлэх сан 11.4 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан 11.8 сая төгрөг, Засаг даргын тамгын газар 4.1 сая төгрөг, Соёлын төв 0.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 184.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 159.7 мянган төгрөг болж 13.7 хувиар буюу 25.2 сая төгрөгөөр төсөвт байгууллагын бараа материал өссөн байна.

Хүснэгт №.3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эдлэх хувь
Тусгай зориулалтын материал	33.1	4.1	(29)	
Эм боох материал	10.3	10.2	(0.1)	
Бичиг хэргийн материал	3.7	3.6	(0.1)	
Аж ахуйн материал	87.4	101.7	14.3	
Сэлбэг хэрэгсэл	2.6	0.0	(2.6)	
Түлш шатах тослох материал	3.3	0.6	(2.7)	
Барилгын засварын материал	34.7	29.4	(5.3)	
Хүнсний материал	9.6	8.8	(0.8)	
Бусад хангамжийн материал	0.1	1.2	1.1	
Дүн	184.9	159.7	(25.2)	
Үүнээс байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	178.5	159.7	(18.8)	
ТӨҮГ болон ОНӨҮГ	6.4	0.0	(6.4)	
Дүн	878.5	838.4	(25.2)	

Эх сурвалж: Баяннуур сумын засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 25.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 209.1 сая, хандиваар 18.5 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 251.6 сая, бусад 1.1 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, 25.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- *ЕБС байгууллагын эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого зохион байгуулах ажлын хэсэг нь тооллого явуулсан ч ажлын тайлан, тооллогын материалыг сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны бүртгэлийн маягтын дагуу бэлтгээгүй, тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй байсан ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.*
- *Сумын Моноسخон цэцэрлэг ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлээгүй шууд гэрээгээр худалдан авах босго үнээс давсан 16.8 сая төгрөгийн хүүхдийн хоолны материалын худалдан авалтыг харьцуулалтын аргаар тендер зохион байгуулаагүй, хүүхдийн хоолны материалыг шууд гэрээгээр худалдан авалт хийсэн байна.*
- *Бараа материалыг бүртгэхдээ УСНББОУС-12 Бараа материалын стандартын дагуу ангилж бүртгээгүй байна. Жишээ нь: Моноسخон цэцэрлэг 7.0 сая төгрөг*
- *ЗДТГ нөөц хөрөнгө болон нэмэлт санхүүжилтийн данснаас худалдан авсан 6.1 сая төгрөгийн УБ шатахуун, бараа материалыг тусад нь бараа материалын тайлан гаргасан боловч няравын тайлан санхүүгийн тайланд бүртгэгдээгүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчсөн байна.*

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 3434.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3304.6 сая төгрөг болж 130.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №.4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	3082.3	3142.3	60.0	
Хуримтлагдсан элэгдэл	(330.8)	(492.1)	(161.3)	
Авто-тээврийн хэрэгсэл	326.4	257.2	(69.2)	
Хуримтлагдсан элэгдэл	(210.6)	(181.8)	(28.8)	
Машин тоног төхөөрөмж/компьютер/	390.6	331.7	(58.9)	
Хуримтлагдсан элэгдэл	(209.3)	(155.9)	(53.4)	
Тавилга, аж ахуйн эд хогшил	181.0	143.1	(37.9)	
Бусад үндсэн хөрөнгө	342.2	399.2	57.0	
Хуримтлагдсан элэгдэл	(133.2)	(164.4)	31.2	
Ном	11.5	12.9	1.4	
Дүн	3434.7	3304.6	(130.1)	
Сумын ЗДТГ	990.2	916.1	(74.1)	
Сумын ИТХ	3.1	6.4	3.3	
Соёлын төв	261.7	249.0	12.7	
Сум хөгжүүлэх сан	0.0	0.0	0.0	
Сургууль	1502.1	1426.1	76.1	
Эмнэлэг	319.9	310.3	9.6	
Цэцэрлэг	356.8	396.7	39.9	
Эмийн эргэлтийн сан	0.8	0.0	(0.8)	
Дүн	3434.7	3304.6	(130.1)	

Эх сурвалж: Баяннуур сумын засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3304.6 сая төгрөг болж, 130.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 12.5 сая, хандиваар 78.4 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 34.3 сая, анхны өртөгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгийг дахин шинэчлэн үнэ тогтоосон 5.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 35.1 сая, акталсан 141.4 сая, үлдэгдэх өртөг нь дуусаагүй хөрөнгийг данснаас хассанаас үүссэн дахин үнэлгээний хорогдол 210.4 сая, худалдан зарцуулсан 32.0 сая, бусад 35.3 сая төгрөгөөр тус тус хасагдснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- *ЕБС нь байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 32 нэр төрлийн 3.9 сая төгрөгийн элэгдлээр анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.*
- *СӨБ нь 22.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал буруу бүртгэсэн нь Сангийн сайдын тушаалаар батлагдсан ашиглалтын хугацааг мөрдөөгүй 11 нр төрлийн тоног төхөөрөмжийг 20, 100 жилээр элэгдүүлж байна. Программ хангамжийг орлогод аваагүй мэдээлэл технологийн зардлаар бүртгэсэн. Мөн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 2 нэр төрлийн хөрөнгө байна. 9 нэр төрлийн хөрөнгийн элэгдэл бодоогүй.*

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 0.2 сая төгрөг болж 6.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №.5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан(-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон өглөг	0.5	0.0	(0.5)	
Байгууллагад төлөх өглөг	5.7	0.2	5.5	
Дүн	6.3	0.2	(6.1)	
Засаг даргын тамгын газар	0.5	0.0	(0.5)	
Сум хөгжүүлэх сан	3.8	0.0	(3.8)	-
Хүн эмнэлэг	0.0	0.2	0.2	
Эмийн эргэлтийн сан	1.8	0.0	(1.8)	
Дүн	6.3	0.2	(6.1)	

Эх сурвалж: Баяннуур сумын засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 0.2 сая төгрөгийн өр байна. Тайлант онд ЖДҮД сангийн зээлийн эргэн төлөлтийг данс андуурсан 3,8 сая төгрөг, ЗДТГ-ын 0.5 сая төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЭМТ нь цэвэр бохир ус, авто машины албан татвар 0.2 сая төгрөгийн өртэй гарсан нь нягтлан бодогчийн тооцооллын буруугаас үүссэн өр байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3898.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3825.5 сая төгрөг болж 73.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1096.9	1096.1	(0.8)	
Хуритлагдсан үр дүн	81.2	8.7	(72.5)	
Хөрөнгийн дахин үнэлгэний зөрүү	2720.7	2720.7		
Дүн	3898.8	3825.5	(73.3)	

Эх сурвалж: Баяннуур сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3825.5 сая төгрөг болж 73.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал болон ашиглалтын хугацаа дууссан барилга байгууламж акталж данснаас хассанаас шалтгаалжээ. Үүнд:

- Засаг даргын тамгын газар тээврийн хэрэгсэл 40.6 сая төгрөг,
- Машин тоног төхөөрөмж ИТХ 3.3 сая, цэцэрлэг 6.1 сая, эмнэлэг 11.6 сая, сургууль 5.2 сая, соёлын төв 2.4 сая, Засаг даргын тамгын газар 35.3 сая төгрөг,
- Тавилга эд хогшил Засаг даргын тамгын газар 9.3 сая, эмнэлэг 2.6 сая, соёлын төв 1.5 сая, цэцэрлэг 6.8 сая, сургууль 11.9 сая, ИТХ 1.1 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Хуримтлагдсан үр дүн 8.7 сая төгрөг болж 72.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүн алдагдалтай тайлагнаснаас шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 337.8 сая төгрөгөөр баталж, 367.9 сая төгрөгийг бүрдүүлэн, 30.2 сая төгрөгөөр буюу 108.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орлогын гүйцэтгэл төгрөг/

/сая

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +, хэмнэлт-
1	Нийт орлого ба тусламжийн дүн	337.8	367.9	30.2
11	Татварын орлого	58.1	88.3	30.2
110	Орлогын албан татвар	58.1	88.3	30.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	23.7	43.0	(19.2)
110002	Үйл ажиллагааны орлого	1.2	1.5	0.3
110003	Хөрөнгийн орлого	9.5	12.6	3.1
110008	Шууд бус орлого	13.0	28.8	15.8
113	Хөрөнгийн албан татвар	1.6	0.9	(0.6)
113002	Бууны албан татвар	1.6	0.9	(0.6)
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7.5	9.6	2.1
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2.0	2.8	0.8

118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2.0	2.7	0.7
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.5	4.0	0.5
1182	<i>Байгалийн нөөц ашигласны төлбөр</i>	1.7	1.7	0.0
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1.7	1.7	0.0
12	Татварын бус орлого	23.5	32.9	9.5
120003	Торгуулийн орлого	21.0	29.7	8.7
120005	Түрээсийн орлого	2.5	3.2	0.7
	Тусламжийн орлого	279.7	279.6	0.0

Эх сурвалж: Баяннуур сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үйл ажиллагааны орлого 129.2 хувь, хадгаламжийн хүүгийн орлого 132.1 хувь, шууд бус орлого 221.8 хувь, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 143.4 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 135.2 хувь, хог хаягдлын хураамжийн орлого 115.0 хувь, торгуулийн орлого 141.7 хувь, түрээсийн орлого 128.7 хувиар тус тус давсан биелэлттэй байна.

Шууд бус суутганы төлөвлөгдсөн орлогоос гадна ноосны урамшуулал 225 өрхийн 7.1 сая төгрөг, өлийн цагаан огтоно устгах ажлын урамшуулал суутган 1.0 сая төгрөг нэмэж орсон. Улсын тэмдэгтийн хураамжаар тамхи согтууулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл 4 аж ахуйн нэгж сунгалт хийсэн байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр нь нэгдсэн “Хужир” арга хэмжээг 9.10 сард 7 хоног бүр 4 удаа гарч хужирын хураамж авах ажлыг зохион байгуулж сумын өрхийн 65 хувийг хамруулан ажилласан байна. Мөн сумын нийт өрхийн 67 хувийг хогны татварт хамруулсан байна. Орон нутгийн өмчийн барилгыг түрээслэхээр 1 иргэн 2 байгууллагатай гэрээ байгуулж орлогын төлөвөлтийг тооцсон ба тайлант онд түрээслэгч 2 нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- *Бууны татвар 0.6 сая төгрөгөөр тасарсан байна.*

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 79.8 сая төгрөгийн 10 алдаа зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- *ЕБС нь өмнөх оны шатахууны зардлаас зориулалт бус зарцуулсан 0.4 сая төгрөгийн төлбөрийн актыг байгууллагын цалингийн зардлаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.*
- *ЕБС нь бараа үйлчилгээний бусад зардлаас урсгал засварт 5.7 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.*
- *ИТХ нь цалингийн зардлаас 0.9 сая төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.*
- *ЗДТГ нь хавсран ажилласны нэмэгдлийг 0.2 сая төгрөгөөр илүү тооцон олгосон байна.*

- ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан шатахууныг замын хуудасгүй зарцуулсан байна.
- СӨБ нь цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй 51.1 сая төгрөгийг шууд зарлаар, цалингийн зардлаас нягтлан бодогчид 2020 оны төсөвт батлагдаагүй ажил хавсран гүйцэтгэсний 1.1 сая төгрөгийн нэмэгдэл, няравт 2020 оны төсөвт батлагдаагүй сахилгын шийтгэлийн дутууг цалингийн зөрүүгээр 0.2 сая төгрөг, цалингийн зардлаас ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 4.7 сая төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, орон нутгаас олгосон 15.1 сая төгрөгийн санхүүжилтыг орон нутгийн хөгжлийн сангаас олгосон санхүүжилтээр тайлагнасан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Баяннуур сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай XI/05 дугаар тогтоолд зааснаар тайлант онд 0.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдаж орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 150 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8 Төвлөрүүлэх орлого төгрөг/

/сая

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗДТГ-ын үндсэн үйл ажиллагааны орлого	0.4	0.6	0.2	150%
Нийт дүн	0.4	0.6	0.2	150%

ЗДТГ-н үндсэн үйл ажиллагааны орлого 0.2 сая төгрөгөөр давсан нь тамгийн газрын буудлын болон каноны орлого өндөр байснаас шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1905.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1905.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 105.4 сая төгрөгөөр бууруулж 1800.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 9.9 сая төгрөг буюу 4.5 хувиар санхүүжилтийг бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

2020 оны төсвийн жилд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 1189.8 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 36.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 813.5 сая төгрөгийн санхүүжилт тус тус ирсэн байна. Мөн 2019 онд Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас 29.7 сая төгрөгийн санхүүжилт авахаас 27.4 сая төгрөгийн санхүүжилт авч 2.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 58.1 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 30.2 сая төгрөгөөр давсан нь улсын тэмдэгтийн хураамжаар тамхи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл 4 аж ахуйн нэгж сунгалт хийсэн байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр нь нэгдсэн “Хужир” арга хэмжээг 9.10 сард 7 хоног бүр 4 удаа гарч хужирын хураамж авах ажлыг зохион байгуулж сумын өрхийн 65 хувийг хамруулан ажилласан байна. Мөн сумын нийт өрхийн 67 хувийг хогны татварт хамруулсан нь шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 23.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 9.5 сая төгрөгөөр давсан нь орон нутгийн өмчийн барилгыг түрээслэхээр 1 иргэн 2 байгуулагатай гэрээ байгуулж орлогын төлөвөлтийг тооцсон ба тайлант онд түрээслэгч 2 нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1591.6 сая төгрөг буюу 82.4 хувьтай байгаа нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан, урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйгээс шалтгаалсан байна. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг хойшлуулсан
- Халаалт цэвэр бохир усыг хэмнэсэн

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 12.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 123.3 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 99.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 76.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц хөрөнгөөс 90.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 42.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.4 сая, нийт 132.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 2.1 сая, норматив зардалд 11.7 сая, эд хогшил урсгал засварын зардалд 0.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил ,

үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 2.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 115.0 сая, бусад урсгал шилжүүлэг 0.2 сая нийт 131.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.02 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1032 мэдээллээс 950 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийн хугацаа болоогүй, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Тухайлбал: Ерөнхий боловсролын сургууль 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 1 хугацаа болоогүй, Цэцэрлэг 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээлэл хугацаа болоогүй, 2 мэдээллийг хоцроосон. Соёлын төв 149 мэдээллээс 133 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 14 мэдээллийг хоцроосон байна. ЭМТ 149 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 8 мэдээллийг хоцроосон, ЗДТГ 149 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 11 мэдээллийг хоцроосон. ИТХ 149 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээлэл хугацаа болоогүй, 11 мэдээллийг хоцроосон байна. СХС,ОНХС Төрийн сан, эргэлтийн эмийн сан 151 мэдээллээс 126 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээлэл хугацаа болоогүй, 23 мэдээллийг хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3		3				100%
Нийт	3		3				100%

/сая төгрөг/

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 тусгай сан, ИТХ болон Соёлын төв түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4 /Баяннуур сумын сургууль, эмнэлэг,ЗДТГ/ “Хязгаарлалттай” 1 /цэцэрлэг/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 227.7 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлснээс шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 227.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн зүйл байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1032 мэдээллээс 950 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийн хугацаа болоогүй, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь шилэн дансны тухай хуулийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Төвлөрүүлсэн захирагчид 227.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 198.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс зөрчил илрүүлснээс 15.1 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 4.5 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 18.2 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 160.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 16 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Авлагатай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: 2020 онд авлага нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.

4.1.2 Эрсдэл: Авлага нэмэгдэнэ.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах зөвлөмж өглөө.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр:	Баяннуур сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БУА-2021/15/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баяннуур сумын Засаг дарга		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2020 онд авлага нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.	0	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Л.Одончимэг С.Наранцэцэг
2	Аудитаар нийт 193.6 сая төгрөгийн 23 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	34.2	Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Л.Одончимэг С.Наранцэцэг
3	Иргэд аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн.	193.5	НӨАТТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Л.Одончимэг С.Наранцэцэг
4	Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1032 мэдээллээс 950 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийн хугацаа болоогүй, 70 мэдээллийг	0	Алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан	Засаг дарга, Санхүү албаны дарга	Л.Одончимэг С.Наранцэцэг

	хугацаа хоцроож байршуулсан байна.		шаардлага хүргүүлэв.		
	Дүн	227.7			